



**ХОВД АЙМГИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ**

2019



БАЙГАЛИЙН ГОЛОМТОТ ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ӨВЧЛӨЛ ГАРСАН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

**ЗӨСТ-ийн сургалт сурталчилгаа хариуцсан
мэргэжилтэн Б.Лхагва-Очир**

2019.03.29





ЗӨСТ-ийн товч танилцуулга

Ховд аймгийн Зооноз өвчин судлалын төв нь анх ГАХӨЭССтанц /Гоц аюулт халдварт өвчнийг эсэргүүцэн судлах станц/ нэртэйгээр 1980 оны 08 дугаар сарын 20-ны өдөр БНМАУ-ын СНЗ-ийн 78-р нууц тогтоолоор 10 ажилтантай байгуулагдсан.

Байгалийн голомтот зоонозын халдварт өвчний чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

Одоогоор манай байгууллага нь Захиргаа аж ахуй, Голомт хяналт-Тархвар судлал, Лабораторийн гэсэн үндсэн 3 тасагтай 22 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна





Үндсэн үйл ажиллагааны чиглэл

1. Голомтын хяналт
2. Тархвар судлал
3. Лаборатори
4. Эрт сэрэмжлүүлэг, сургалт сурталчилгаа
5. Зоонозын халдварт өвчний сэжигтэй дуудлага, хүний өвчлөл, түүнд үзүүлэх хариу арга хэмжээ





Ховд аймгийн нутагт одоогийн байдлаар илрүүлсэн байгалийн голомтот зоонозын халдварт 20 өвчин байна. ЭМС-ын 2006 оны 403 дугаар тушаалаар батлагдсан тэргүүлэх чиглэлийн 8 өвчнөөс 7 нь, судлан шинжлэх шаардлагатай 10 өвчний 5 нь, нэмэлтээр судалгаа, шинжилгээнд хамруулах шаардлагатай 11 өвчний 7 нь тус тус байна.





ХОВД АЙМАГТ ЗОНХИЛОН ТОХИОЛОГДДОГ ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧЛӨЛҮҮД

- 1. ТАРВАГАН ТАХАЛ**
- 2. БООМ**
- 3. ГАЛЗУУ**
- 4. ХАЧИГТ ХАЛДВАР**





ТАРВАГАН ТАХАЛ

Олон улсын дүрмээр зохицуулагддаг байгалийн голомтот хурц халдварт өвчин юм.

Богино хугацаанд олон хүнийг хамран өвчлүүлж, эрт оношилж зөв эмчлээгүй тохиолдолд богино хугацаанд хүндрэн үхэлд хүргэх аюултай өвчин юм.





ТАРВАГАН ТАХАЛ

Тарваган тахал өвчнөөс хэрхэн сэргийлэх вэ?

Вакциныг 6 наснаас дээш насныханд тарих заалттай

Тарваганы түрхий мах, ад эрхтэнг хот, суурин газарт оруулахгүй, эмчилгээний зорилгоор хэрэглэхгүй байх

Тарвага болон мэрэгч амьтны бөөс, бүүрэгт хазуулахаас сэргийлэх

Олноор үхсэн мэрэгч амьтад болон тарвагатай таарвал гар хүрэхгүйгээр мэргэжлийн байгууллагад яаралтай мэдэгдэх

Тарваган тахлын дархлаажуулалтад хамрагдах /жил бүрийн VII сарын 3 дах бэлдээ хоногт/

Хэрэв та тарваган тахлын эрсдэлд өртсөн, эмгэмзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандгах

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар тарвага





ТАРВАГАН ТАХАЛ

Халдвар дамжих зам

Шууд хавьтлын зам: өвчтэй тарвага агнах, арьс өвчих, мах эвдэх явцад арьс салстын бүтэн байдал алдагдах, өвчтнийг асрах, халдвартай эд, зүйлстэй хамгаалах өмсгөлгүй харьцсанаас халдварт өртөнө.

Дам халдварын зам: шимэгчид хазуулсан тохиолдолд халдварлана.

Агаар дуслын зам: тарваган тахлын уушгины хэлбэрээр өвчилсөн хүнээс хүнд дамжина.

Хоол хүнсний зам: тарваганы түүхий эд, эрхтэн, дутуу боловсруулсан махыг хүнсэнд хэрэглэсэн тохиолдолд халдварлана.





ТАРВАГАН ТАХАЛ

Илрэх шинж тэмдэг

Булчирхайн хэлбэрийн үед: Тунгалагийн булчирхай хавдах, эмзэглэлтэй болох, барьцалдсан бэрсүү үүсэх

Уушигны хэлбэрийн үед: Цустай, цэртэй ханиалгах, цээжээр өвдөх, амьсгаадах зэрэг шинж тэмдгээс хоёр нь илэрэх

Гэдэсний хэлбэрийн үед: хэвлийгээр өвдөх, бөөлжих, суулгах шинж тэмдэг илэрсэн

Үжил хэлбэрийн үед: арьсаар цусархаг тууралт гарах, цус түгмэлээр бүлэгнэх хам шинж илрэх, олон булчирхай томрох, олон эрхтний дутал илэрсэн.





ТАРВАГАН ТАХАЛ





ТАРВАГАН ТАХАЛ

А зэрэглэл-хүн өвчлөх магадлал өндөр

- | | | |
|---------|--------|-------|
| ➤ Цэцэг | Булган | Үенч |
| ➤ Мөст | Манхан | Алтай |

Б зэрэглэл-хүн өвчлөх магадлал дунд

- | | | | |
|---------------|----------|------------|-------|
| ➤ Дуут | Чандмань | Эрдэнбүрэн | Зэрэг |
| ➤ Мөнххайрхан | Ховд | Дарви | |

В зэрэглэл-хүн өвчлөх магадлал бага

- | | |
|----------|-----------|
| ➤ Мянгад | Буянт |
| ➤ Дөргөн | Жаргалант |





БООМ

Боом өвчин нь арьс, тунгалгийн зангилаа болон дотор эрхтэнд шүүдэст цусархаг үрэвсэл бий болгож өвөрмөц хатиг буюу үжил үүсгэдэг хордлогот, нянгийн гаралтай хүн, мал, амьтны цочмог халдварт өвчин юм.





БООМ

Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх



Малчныг вакцинжуулах



Малын эмчид үзүүлэх,
оношлуулах



Ил задгай хаяхгүй байх

Үхсэн малыг
шатааж устгах



Мах, түүхий эдийг
ашиглахгүй байх



Малыг вакцинжуулах

Малчин бээлий
өмсөж халдвар
авахаас сэргийлэх





БООМ

Халдвар дамжих зам

Шууд хавьтлын зам: өвчилсөн, үхсэн мал, түүний арьс, сэг зэм, хөрстэй шууд харьцах үед гэмтсэн арьсаар халдвар дамжина.

Дам халдварын зам: цус сорогч хос далавчтан, үе хөлтөнд хазуулсан тохиолдолд дамжих эрсдэлтэй.

Агаар дуслын зам: мал нядалгааны газар, түүхий эдийн боловсруулалт хийдэг ажилчид өртөх эрсдэлтэй.

Ходоод гэдэсний хэлбэр: дутуу боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн хүнсэнд хэрэглэсэн тохиолдолд халдвар дамжина.





БООМ

Эмнэлзүйн хэлбэр:

1. Арьсны хэлбэр
2. Хавант хэлбэр
3. Цэврүүт хэлбэр
4. Ёлом төст хэлбэр
5. Уушгины хэлбэр
6. Түгмэл хэлбэр
7. Ходоод-гэдэсний хэлбэр
8. Мэнэн хэлбэр





БООМ

Хариу арга хэмжээ:

Мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтнүүдээс бүрдсэн хариу арга хэмжээний баг ажиллана.

Эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

Эрхзүйн орчны хүрээнд мэргэжлийн байгууллагууд хамтран дэгдэлтийн судалгааг хийж дүгнэлт гаргана.

Сэжигтэй өвчтөнг халдвартын эмнэлэг, тасагт тусгаарлан хэвтүүлж эмчлүүлнэ.

Халдвартын эх уурхайг илрүүлэх зорилгоор гадаад орчны сорьц цуглуулж шинжилнэ.

Уушгины хэлбэрийн үед хөл хорио тогтоон тарваган тахлын уушгины хэлбэртэй адилтган халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.





БООМ

Голомтын идэвхитэй сумд:

1. Жаргалант сум

2. Буянт сум

3. Мянгад сум

4. Ховд сум





ГАЛЗУУ

**Галзуу өвчин нь вирусээр
үүсгэгддэг, төв мэдрэлийн
тогтолцоог сонгомлоор
гэмтээдэг, мал амьтнаас хүнд
халдварладаг зоонозын
цочмог халдварт өвчин.**





ГАЛЗУУ

Галзуу өвчнөөс хэрхэн сэргийлэх вэ?

Гэрийн тэжээмэл амьтдыг вакцинжуулах

Хот суурингийн эзэнгүй нохой, муур устгах

Галзуу өвчин мал, амьтдын дунд гарч байгаа тохиолдолд малаа вакцинжуулах

Галзуугийн эсрэг вакцин тариулж байгаа нөхцөлд эмийн зааврын дагуу бүрэн тунг хийлгэх





ГАЛЗУУ

Галзуугийн сэжигтэй амьтанд уруулж, шүлсдүүлсэн тохиолдолд

- Галзуугийн сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн тохиолдолд яаралтай эмнэлгийн байгууллагад хандах

- Уруулсан шархыг савангийн уусмал, 5%-ийн иодын уусмалаар арчиж, цэвэрлэх
- Галзуугийн эсрэг вакцин, ийлдэс Яаралтай тариулах

- Хүн урсан эзэнтэй нохойг 10 хоног уяатай байлгаж, ажиглах
- Хүн урсан эзэнгүй нохойг засаг захиргаа, мал эмнэлгийн байгууллагад мэдээлж устгуулан лабораторийн шинжилгээнд хамруулах

Галзуу өвчин хүнд яаж халддаг вэ?

Зэрлэг



- Чоно
- Үнэг
- Хярс
- Сарьсан багваахай
- Зурам
- Баавгай
- Өмхий хүрэн
- Бусад

Гэрийн тэжээмэл



- Адуу
- Тэмээ
- Үхэр
- Хонь
- Ямаа
- Нохой
- Муур
- Гахай
- Бусад





ХАЧИГТ ХАЛДВАР

Монгол улсад 2005 оноос, Ховд аймагт 2008 оноос анх удаа хачигт халдварын хүний өвчлөл гарч байсан.

Сүүлийн 5 жил Ховд аймагт нийт 242 хачигт халдварын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага ирснээс лабораторийн шинжилгээгээр 81 тохиолдол нь батлагдсан.





ХАЧИГТ ХАЛДВАР

Хачиг амьдралынхаа явцад **3** удаа цус сордог



Өндөр халуурах, толгой, үе мөч хүчтэй өвдөх, ууц нуруугаар шархирч өвдөх, дотор муухайрах, бөөлжих, тууралт гарах зэрэг шинж тэмдэг илрэх буюу хачиганд хазуулсан тохиолдолд эмнэлэгт яаралтай хандаарай!





ХАЧИГТ ХАЛДВАР





ХАЧИГТ ХАЛДВАР

ХАЧИГТ ХАЛДВАРААС ХЭРХЭН СЭРГИЙЛЭХ ВЭ?



Тод
өнгийн,
битүү
хувцас,
малгай
ӨМСӨХ



Хачиг
дайжуулагч
хэрэглэх



2-3 цаг тутамд
биедээ хачиг
байгаа эсэхийг
шалгах





✓ ЭМС-ын 2017 оны 04 сарын 21 өдрийн А/160 дугаар тушаал А/161 дүгээр тушаал

✓ 16 сум бүгд голомт хяналтын эмчтэй





**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**

**ЗӨСТ
2019**

